



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, Газрын дүрмийн 2.5.3 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оны хагас жилийн үндсэн хөрөнгө, материалын тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Д.Ганболд	Захиргааны хэлтсийн дарга
Гишүүд:	Ш.Ундармаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн
	С.Баяржаргал	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
	Б.Ишдорж	Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Д.Болорчимэг	Мэдээлэл, сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2. Эд хөрөнгийн тооллогыг 2019 оны 06 дугаар сарын 28-ны дотор багтаан зохион байгуулж, дүн мэдээг танилцуулахыг комиссын дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500237